

2024 оны 11-р сарын 1-ний өдрөөс

Ур чадварын дадлагаа хэрэгжүүлэх боломжгүй болсон “Зайлшгүй нөхцөл байдал” үүссэн тохиолдолд дадлага хэрэгжүүлэгч газрыг хэрхэн солих талаар ойлгомжтой болгосон.

1 “Зайлшгүй нөхцөл байдал” гэдгийг ойлгомжтой болгосон.

Жишээлбэл дараах тохиолдлууд болно.

- (1) Компанийн ажилтан нь таныг цохих, заналхийлэх, дарамтлах тохиолдолд
- (2) Компанийн ажилтан нь хууль тогтоомжийг огт дагаж мөрдөөгүй тохиолдолд
 - Ур чадварын дадлагын төлөвлөгөөнөөс өөр ажил хийж байгаа
 - Цалингаа авч чадахгүй байгаа
 - Оршин суух карт, гадаад паспортаа хураалгасан
 - Зугаацахаар явах, гадуур гарах, хайр сэтгэл зэргийг хязгаарласан
 - Ур чадварын дадлагын хугацаа хараахан дуусаагүй байтал нутаг буцаагдах болсон
 - Хууль бусаар оршин сууж буй гадаадын иргэд ажиллаж байгаа
- (3) Компанийн ажилтан нь гэрээг огт дагаж мөрдөөгүй тохиолдолд

→ Дэлгэрэнгүйг эндээс ■ (ОТГТ вэбсайт)



2 “Зайлшгүй нөхцөл байдал” үүссэн тохиолдолд дадлага хэрэгжүүлэгч газрыг хэрхэн солих талаар ойлгомжтой болгосон.

- “Зайлшгүй нөхцөл байдал” үүссэн тохиолдолд, хянагч байгууллага болон компанидаа дадлага хэрэгжүүлэгч газраа солих хүсэлтэй байгаагаа мэдээлэхэд зориулсан маягт гаргасан.
- “Зайлшгүй нөхцөл байдал” үүссэн гэдгээ мэдээлэхдээ, тухайн байдлыг харуулсан зураг эсвэл бичлэг байвал дадлага хэрэгжүүлэгч газрыг солиход хялбар байх тохиолдол байдаг.

→ Дэлгэрэнгүйг эндээс ■ (ОТГТ вэбсайт)



3 Шинээр дадлага хэрэгжүүлэгч газар хайж байх хугацаандаа болон шинээр дадлага хэрэгжүүлэгч газар хайсан ч олдохгүй байгаа тохиолдолд, Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газарт бичиг баримт бүрдүүлэлт хийвэл ажил хийх боломжтой болох магадлалтай.

→ Дэлгэрэнгүйг эндээс ■ (Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газрын вэбсайт)



Зөвлөгөө өгөх газар

Санаа зовоосон асуудлаа юуны өмнө хянагч байгууллага, компанийн хүнтэйгээ зөвлөөрэй. Хянагч байгууллага, компанийн хүндээ дадлага хэрэгжүүлэгч газраа солих хүсэлтэй байгаагаа хэлсэн ч шинэ дадлага хэрэгжүүлэгч газар хайж өгөхгүй байх, эсвэл хянагч байгууллага, компанийн хүндээ хэлж болохгүй шалтгаан байгаа бол, Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага (ОТИТ)-ын орон нутаг дахь оффис, салбартай зөвлөнө үү.
Цаг: Ажлын өдөр 9:00 ~ 17:00

Орон нутаг дахь оффис	Хариуцах бүс	Хаяг, утасны дугаар
Саппоро оффис	Хоккайдо	〒060-0034 Хоккайдо Саппоро хот Чюүо-кү Киташижёо Хигаши 2-8-2 Марүито Киташижёо барилга 5 давхар ☎011-596-6445
Сэндай оффис	Аомори муж, Иватэ муж, Мияги муж, Акита муж, Ямагата муж, Фүкүшима муж	〒980-0803 Мияги муж Сэндай хот Аоба-кү Кокүбүн-чёо 1-2-1 Сэндай Фүкоку Сэймэй барилга 6 давхар ☎022-398-6126
Токио оффис	Точиги муж, Гүнма муж, Чиба муж, Сайтама муж, Токио хот, Канагава муж, Яманашим муж	〒101-0041 Токио хот Чиёда-кү Канда Сүда-чёо 2-7-2 Urban Center Канда Сүда-чёо 4 давхар ☎03-5577-5143
Мито салбар	Ибараки муж	〒310-0062 Ибараки муж Мито хот Оо-мачи 1-2-40 Асахи Сэймэй мито барилга 3 давхар ☎029-350-8856
Нагано салбар	Нийгата муж, Нагано муж	〒380-0825 Нагано муж Нагано хот Минами Нагано Сүэхиро-чёо 1361 Накажима Кайкан барилга 6 давхар ☎026-217-3556
Нагоя оффис	Шизүока муж, Гифү муж, Айчи муж, Миэ муж	〒460-0008 Айчи муж Нагоя хот Нака-кү Сакаэ 4-15-32 Никкэн Сүмио барилга 5 давхар ☎052-228-0627
Тояма салбар	Тояма муж, Ишикава муж, Фүкүи муж	〒930-0004 Тояма муж Тояма хот Сакүрабаши гудамж 5-13 Тояма Коогин барилга 12 давхар ☎076-481-7560
Осака оффис	Шига муж, Киото тойрог, Осака тойрог, Хёёго муж, Нара муж, Вакаяма муж	〒541-0043 Осака тойрог Осака хот Чюүо-кү Коорайбаши 4-2-16 Осака Асахи Сэймэй байр 3 давхар ☎06-6210-3352
Хирошима оффис	Тоттори муж, Шиманэ муж, Окаяма муж, Хирошима муж, Ямагүчи муж	〒730-0051 Хирошима муж Хирошима хот Нака-кү Оотэ-мачи 3-1-9 Хирошима Рижёо доори барилга 3 давхар ☎082-207-3029
Такамацү оффис	Токушима муж, Кагава муж	〒760-0023 Кагава муж Такамацү хот Котобүки-чёо 2-2-10 Такамацү Котобүки-чёо Прайм барилга 7 давхар ☎087-802-5850
Мацүяма салбар	Эхимэ муж, Коочи муж	〒790-0003 Эхимэ муж Мацүяма хот Санбан-чёо 7-1-21 Жибралтар Сэймэй мацүяма барилга 2 давхар ☎089-909-4110
Фүкүока оффис	Фүкүока муж, Сага муж, Нагасаки муж, Ооита муж, Окинава муж	〒812-0029 Фүкүока муж Фүкүока хот Хаката-кү Комондо-чёо 1-1 Никкан Коогёо Шинбүн компани баруун салбар 7 давхар ☎092-710-4083
Күмамото салбар	Күмамото муж, Миязаки муж, Кагошима муж	〒860-0806 Күмамото муж Күмамото хот Чюүо-кү Ханабата-чёо 1-7 МҮ Күмамото барилга 2 давхар ☎096-223-5372

- Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газарт бүрдүүлэх бичиг баримтын талаар Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газартай зөвлөнө үү.
Гадаад иргэдийн оршин суух ерөнхий мэдээллийн төв
Утас 0570-013904
Цаг: Ажлын өдөр 8:30 ~ 17:15

